

1994 оны ТХЕХ, худалдааны ерөнхий хэлэлцээрийн тухай Марракешийн Протокол

Гишүүд,

1947 оны ТХЕХ-ийн хүрээнд, Уругвайн үе шатны тухай Сайд нарын тунхаглалын дагуу хэлэлцээ хийн,

үүгээр дараахь зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

1.Энэхүү Протоколд хавсаргасан аливаа гишүүнд хамаарах жагсаалт нь ДХБ-ын тухай Хэлэлцээр тухайн гишүүний хувьд хүчин төгөлдөр болох өдөр уг гишүүнд хамаарах 1994 оны ТХЕХ-ийн жагсаалт болно. Нэн буурай хөгжилтэй орнуудын хувьд авах арга хэмжээний тухай Сайд нарын шийдвэрийн дагуу гаргасан аливаа жагсаалтыг энэхүү Протоколд хавсаргагдсан гэж үзнэ.

2.Гишүүн бүрийн тохиролцсон тарифын бууралтыг гишүүний жагсаалтад өөрөөр зааж болохоос бусад тохиолдолд тэнцүү хэмжээний таван үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Уг гишүүний жагсаалтад өөрөөр зааж болохоос бусад тохиолдолд анхны ийм бууралт нь ДХБ-ын тухай Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн мөрдөгдөх бөгөөд цаашдын бууралт бүр нь дараагийн жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөх бөгөөд сүүлчийн бууралтын хэмжээ нь ДХБ-ын тухай Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс хойших дөрвөн жилийн хугацаанаас хэтрэхгүйгээр мөрдөгдөж эхлэнэ. Гишүүний жагсаалтад өөрөөр заагаагүй бол, ДХБ-ын тухай Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болсноос нь хойш хүлээн зөвшөөрч буй гишүүн нь энэхүү Хэлэлцээр түүний хувьд хүчин төгөлдөр болох өдөр, урьд нь хийсэн бүх тарифын бууралтыг өмнөх өгүүлбэрийн дагуу дараагийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөх үүрэг хүлээсэн бууралтын хамт мөрдөх бөгөөд үлдэж буй бүх тарифын бууралтыг өмнөх өгүүлбэрт дурдсан хуваарийн дагуу мөрдөнө. Буурсан тарифыг үе шат бүрт аравтын бутархайн эхний орноор хураангуйлна. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд, Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлд заасны дагуу бууралтын шатлалыг жагсаалтын холбогдох хэсгүүдэд дурдсаны дагуу хэрэгжүүлнэ.

3.Хүсэлт гарвал, энэхүү Протоколд хавсаргасан жагсаалтуудад дурдсан буулт болон үүрэг амлалтын хэрэгжилтийг гишүүд олон талт хуралдаанаар хянан хэлэлцэнэ. Энэ нь ДХБ-ын тухай Хэлэлцээрийн Хавсралт 1А-д дурдсан хэлэлцээрүүдийн дагуу гишүүдийн эдлэх эрх, үүргийн үйлчлэлийг хөндөхгүй¹.

4.Энэхүү Протоколд хавсаргасан гишүүнд хамаарах жагсаалт нь 1 дэх хэсгийн заалтын дагуу 1994 оны ТХЕХ-ийн хавсралт болсны дараа, жагсаалт нь 1994 оны ТХЕХ-ийн хавсралт болж амжаагүй байгаа Уругвайн үе шатны аль нэг оролцогч гол нийлүүлэгч нь болох аливаа бүтээгдэхүүний хувьд тухайн гишүүн протоколд хавсаргасан жагсаалт дахь хөнгөлөлтөө бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хэдийд ч царцаах, эсхүл цуцлах эрхтэй. Гэхдээ зөвхөн Барааны худалдааны зөвлөлд хөнгөлөлтийг ингэж царцаах, эсхүл цуцлах аливаа үйлдлийн тухай мэдэгдэл бичгээр өгсөн, түүнчлэн холбогдох жагсаалт нь 1994 оны ТХЕХ-ийн жагсаалт болсон бөгөөд тухайн барааны томоохон нийлүүлэгчийн ашиг сонирхол бүхий аливаа гишүүнтэй хүсэлт тавьсан тохиолдолд зөвлөлдсөний дараа ийм арга хэмжээг авна. Ийнхүү царцаагдсан, эсхүл цуцлагдсан аливаа хөнгөлөлт нь томоохон нийлүүлэгчийн ашиг сонирхолтой гишүүний жагсаалт нь 1994 оны ТХЕХ-ийн жагсаалт болсон өдөр болон түүнээс хойш үйлчилж эхлэх ёстой.

5.(a) Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтын үйлчлэлийг хөндөхгүйгээр, 1994 оны ТХЕХ-ийн 2 дугаар зүйлийн 1(b)² болон (c) хэсгийн

¹ **Монгол редакцийн тэмдэглэл:** without prejudice

² **Англи редакцийн тэмдэглэл:** эх хувьд "1:(b)" гэж алдаатай бичигдсэн.

заалтад Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн огноог эшлэх зорилгын үүднээс, энэхүү Протоколд хавсаргасан хөнгөлөлтийн жагсаалт дахь хөнгөлөлт эдлэх бүтээгдэхүүн тус бүрийн хувьд мөрдөж эхлэх хугацаа нь энэхүү Протокол байгуулсан огноо байна гэж үзнэ.

(b)1994 оны ТХЕХ-ийн 2 дугаар зүйлийн 6 (a) хэсэгт Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн огноог эшлэх зорилгын үүднээс, энэхүү Протоколд хавсаргасан жагсаалтыг мөрдөж эхлэх огноо нь тус Протокол байгуулсан огноо байна гэж үзнэ.

6. Жагсаалтуудын III хэсэгт заасан тарифын бус арга хэмжээтэй холбогдох хөнгөлөлтийг өөрчлөх, эсхүл цуцлах тохиолдолд, 1994 оны ТХЕХ-ийн 28 дугаар зүйлийн заалтууд болон 1980 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан “28 дугаар зүйлийн дагуух хэлэлцээний процедур” (BISD 27S/26-28) үйлчилнэ. Энэ нь 1994 оны ТХЕХ-ийн дагуу гишүүний хүлээсэн эрх, үүргийн үйлчлэлийг хөндөхгүй.

7. Энэхүү Протоколд хавсаргасан жагсаалтаар аливаа бүтээгдэхүүний хувьд, ДХБ-ын тухай Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө 1947 оны ТХЕХ-ийн жагсаалтад байсан тийм бүтээгдэхүүнд эдлүүлж байснаас дутуу нөхцөл олгосон байх аливаа тохиолдолд, тухайн жагсаалтад хамаарах гишүүн өөр үед 1947 оны ТХЕХ, эсхүл 1994 оны ТХЕХ-ийн 28 дугаар зүйлийн холбогдох заалтуудын дагуу авах ёстой байсан зохих арга хэмжээг авсан байна гэж үзнэ. Энэ хэсгийн заалтыг зөвхөн Египет, Перу, Өмнөд Африк болон Уругвайн хувьд мөрдөнө.

8. Энд хавсаргасан жагсаалтуудын англи, франц, испани хэлээрх бичвэр нь хавсралт тус бүрт заасан ёсоор адил хүчинтэй эх хувиуд болно.

9. Энэхүү Протоколын огноо нь 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр байна.